



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 8 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 318

Улаанбаатар  
хот

Төрийн өмчит хуулийн этгээд  
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.1, Иргэний хуулийн 31.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, засаглалыг сайжруулах зорилгоор “Эрчим хүчний хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болон “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийлүүлэн “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

3. “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус эзэмшүүлсүгэй.

4. “Эрчим хүчний хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийлүүлсэнтэй холбогдуулан хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих журмын дагуу “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлэх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгасугай.

5. “Эрчим хүчний хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 3 хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 16,900,998,000.0 (арван зургаан тэрбум есөн зуун сая есөн зуун ерэн найман мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан барилга байгууламжийг “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

6. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 1,584,648,979.0 (нэг тэрбум таван зуун наян дөрвөн сая зургаан зуун дөчин найман мянга есөн зуун далан есөн) төгрөгийн балансын үнэ бүхий 3 дугаар хавсралтад заасан барилга байгууламжийг Эрчим хүчний яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

7. Энэ тогтоолын 4, 5-д заасан үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрчим хүчний хөгжлийн төв байгуулах тухай" Засгийн газрын 2012 оны 51 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Эрчим хүчний сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Н.ТАВИНБЭХ



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/234

Улаанбаатар хот

Төрийн өмчийг бусдад ашиглуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.1, 27.1, 28.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 24 -ний өдрийн 318 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан, тус яаманд балансаас балансад шилжиж ирсэн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 1,584,648,979.0 төгрөгийн балансын үнэ бүхий барилга байгууламжийг 5 жилийн хугацаанд "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид ашигнуулсугай.

2. Барилга байгууламжийг ашиглуулах талаар ашиглалтын гэрээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгуулан ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Дагдан нарт тус тус даалгасугай.

3. Барилга байгууламжийн ашиглалтын хэвийн, тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор урсгал зардлыг тухай бүр төлөх болон барилгын засвар үйлчилгээний ажлын гэрээг тус яамны өмнөөс холбогдох хуулийн этгээдтэй байгуулах эрхийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Р.Дагдан/- д олгосугай.



СӨЖИЛСҮРЭН

170600543

Засгийн газрын 2022 оны 318 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт

**"СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРААС ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД БАЛАНСААС  
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Анхны үнэ, (мян,төг)	Хуримтлагдсан элэгдэл (мян,төг)	Үлдэгдэл өртөг (мян,төг)	Бодит үнэ (мян,төг)
1.	Газар	12430.7	м.кв	0	0	0	73,092,516.00
2.	Оффисын барилга	825.09	м.кв	228,096,160.09	131,553,834.76	96,542,325.33	497,466,505.52
3.	Механик засварын цех, агуулах, гараж, дулааны узельтэй барилга	902.59	м.кв	249,521,032.58	143,910,574.26	105,610,458.32	513,976,677.01
4.	Үйлдвэр, гаражтай барилга	538.12	м.кв	148,763,290.14	85,798,821.42	62,964,468.73	203,695,939.10
5.	Агуулахын барилга	443.6	м.кв	122,633,233.31	70,728,382.48	51,904,850.83	170,002,686.37
6.	Туршилтын байр	22.85	м.кв	6,316,883.19	3,643,232.00	2,673,651.19	2,124,671.55
7.	Харуулын байр	13.18	м.кв	1,518,000.00	1,518,000.00		1,231,543.69
8.	Дулааны шугам	256.5	м	22,000,000.00	22,000,000.00		58,420,440.00
9.	Бохирын шугам	330	м	300,000.00	300,000.00		64,638,000.00
	Нийт дүн			779,148,559.31	459,452,844.92	319,695,754.39	1,584,648,979.24

БАТЛАВ.  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.ТАВИНБЭХ

БАТЛАВ.  
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



Р.ДАГДАН

### БАРИЛГА БАЙГУУЛАМЖ АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 11 дүгээр  
сарын 5-ны өдөр

№.....

1/ 999-2022/01

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид "гэрээ" гэх)-г нэг талаас Эрчим хүчний яам (цаашид "барилга эзэмшигч" гэх) түүнийг төлөөлж Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, нөгөө талаас тус барилгыг ашиглагч "УБЦТС" ТӨХК (цаашид "барилга ашиглагч" гэх) түүнийг төлөөлж Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга А.Энхбат нар (хамтад нь "талууд" гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 339-342 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/234 дугаартай тушаалыг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Барилга эзэмшигч нь нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай энэхүү гэрээний салшгүй хэсэг болох 1 дүгээр хавсралтад заасан барилга байгууламжийг гэрээнд заасан зориулалт, нөхцөлөөр барилга ашиглагчид ашиглуулах, барилга ашиглагч нь барилгыг зориулалтын дагуу ашиглахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

#### Хоёр. Барилга байгууламж ашиглах зориулалт

2.1. Барилга ашиглагч нь Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах энэхүү гэрээний 1 дүгээр хавсралтад заасан барилга байгууламжийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Кабель ашиглалтын төв үйл ажиллагаа явуулах зориулалтаар Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/234 дугаар тушаал батлагдсан өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд ашиглах бөгөөд гэрээний хугацаа нь энэхүү тушаал хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдрөөс эхлэн тоологдоно;

2.2. Барилга байгууламжийн оффисын барилгын 1 дүгээр давхарын 105 тоот /агуулахын өрөө/, 3 дугаар давхарын 301, 302, 303 тоот өрөө, засварын цехийн дунд /хаалга/ талын гаражийг ашиглах эрх нь барилга эзэмшигчид хэвээр хадгалагдана;

2.3. Энэхүү гэрээний 2.2-т заасан барилга байгууламжийг ашиглалтын 5 жилийн хугацаанд Эрчим хүчний яам ашиглана. Бусад барилга байгууламжийг "УБЦТС" ТӨХК зориулалтын дагуу ашиглана;

2.4. Барилга ашиглагч нь барилгыг эзэмшигчийн зөвшөөрсөн зориулалтаас өөр зориулалтаар ашиглах болон аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх, хөлслөх, түрээслүүлэх ашиглуулахыг хориглоно.

**Гурав. Барилга байгууламж ашиглах төлбөр тооцоо,  
нөхцөл, хугацаа**

3.1.Барилга эзэмшигч нь Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/234 дугаар тушаалын дагуу тушаал батлагдсан өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд барилга байгууламжийг үнэ төлбөргүй ашиглуулна;

3.2.Барилга ашиглагч нь Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/234 дугаар тушаалд заасны дагуу барилга байгууламжийн хэвийн, тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор ашиглалтын зардлыг тухай бүр төлөх болон барилга байгууламжтай холбогдон гарах засвар, үйлчилгээг тогтмол хийнэ;

3.3.Энэхүү гэрээний 2.2-т заасан барилга байгууламжийн урсгал зардал болон засвар үйлчилгээг гэрээний хугацаанд ашиглагч хариуцна;

3.4.Энэхүү гэрээний хавсралтад заасан барилга байгууламжид хийсэн их засвар болон инженерийн шугам сүлжээнд хийсэн засварын ажлыг акт үйлдэн гэрээний хугацаа дуусгавар болоход ашиглуулагчид хүлээлгэн өгнө;

3.5.Онцгой болон шаардлагатай тохиолдолд барилга байгууламжид нэмэлтээр хийх засвар үйлчилгээ нь гэрээний нэгдүгээр хавсралтад заасан засварын ажлаар хязгаарлагдахгүй болно.

#### **Дөрөв. Талуудын эрх, үүрэг.**

4.1.Барилга эзэмшигчийн эрх, үүрэг:

4.1.1.Барилгыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглахыг шаардах, ашиглалтад хяналт тавих эрхтэй;

4.1.2.Барилга ашиглагчийг гэрээний хавсралтад заасан барилга байгууламжид хийх засвар, үйлчилгээний ажлыг хийхийг шаардах эрхтэй;

4.1.3.Эрчим хүчний сайдын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/234 дугаар тушаалын хавсралтад заасан барилга байгууламжаас энэхүү гэрээний 2.1-т заасан оффисын барилгын 1-р давхарын агуулахын өрөө, 3-р давхарын 3 өрөө болон дулаан гаражийг үнэ төлбөргүй ашиглах эрхтэй;

4.1.4.Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд барилга ашиглагчид гэрээнд заасан зориулалтын дагуу барилгыг ашиглах нөхцөл, боломжийг бүрдүүлэх үүрэгтэй.

4.2.Барилга ашиглагчийн эрх, үүрэг:

4.2.1.Барилгад учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй;

4.2.2.Барилгын засвар, үйлчилгээний ажлын гэрээг Эрчим хүчний яамны өмнөөс байгуулах эрхтэй;

4.2.3.Барилга эзэмшигчийн барилга байгууламжид гэрээний хавсралтад заасан засвар үйлчилгээг хийх үүрэгтэй;

4.2.4.Барилга эзэмшигчийн ашиглаж байгаа оффисын өрөө, агуулах, гаражийн ашиглалтын зардлыг хариуцан төлөх үүрэгтэй;

4.2.5.Барилгыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй.

#### **Тав. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах.**

5.1.Барилга эзэмшигч нь барилгыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах үүргээ биелүүлээгүй, энэхүү гэрээний 2.4 дэх хэсгийг зөрчсөн бол барилга эзэмшигч энэхүү гэрээг нэг талын санаачилгаар хэдийд ч цуцлах эрхтэй;

5.2.Эрх бүхий байгууллагаас барилгыг ашиглуулахгүй байх шийдвэр гарсан тохиолдолд гэрээг цуцлагдсанд тооцно;

5.3.Гэрээ цуцлах тухай мэдэгдлийг барилга ашиглагчид өгснөөр гэрээ цуцлагдсанд тооцно. Барилга ашиглагч нь гэрээ цуцлах тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор барилга эзэмшигчид хүлээлгэн өгнө.

### **Зургаа.Талуудын хүлээх хариуцлага**

6.1.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

### **Долоо. Бусад.**

7.1.Гэрээнээс үүдэлтэй маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэх бөгөөд эс тохиролцвол шүүхээр шийдвэрлүүлнэ;

7.2.Гэрээнд талууд зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд аль нэг тал дангаараа өөрчлөлт оруулахыг хориглоно. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна;

7.3.Гэрээг 2 хувь үйлдэж, Эрчим хүчний яам болон "УБЦТС" ТӨХК нэг нэг хувийг хадгална. Талуудад хадгалагдсан хувиуд нь хууль зүйн ижил хүчинтэй байна;

7.4.Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

#### **ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:**

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

З.МӨНХ-ОРГИЛ

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Л.МӨНХЖАРГАЛ

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ж.ЖАНАРБААТАР

#### **УБЦТС ТӨХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

А.ЭНХБАТ

ТӨЛӨВЛӨЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ЭРДЭНЭЧУЛУУН

ЗХНХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЭРДЭНЭТУЯА